



Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах
мэргэжилтэн Б.Болормаа
2020.10.13



Сангийн яамны Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 2 дугаар сард боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд нийт 19 ажлыг гүйцэтгэхээр тусгасан. Төлөвлөгөөнд арга хэмжээг зохион байгуулахад зориулсан зардлыг /6 700 000 төгрөг/ тусгаж өгсөн.

**САНГИЙН ЯАМНЫ ЖЕНДЭРИЙН ОРОН ТООНЫ БУС САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах ажилтан	Шалгуур үзүүлэлт	Зардал	Тайлбар
Зорилт 1. <u>Жендэрийн</u> эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж мэдээллийг яамны ажилтнуудад олгох, сургалт зохион байгуулах						
1.1	<u>Жендэрийн</u> хорооны салбар зөвлөлийн гишүүдийг чадавхыг бэхжүүлэх.	2 дугаар улиралд	Яамны <u>жендэрийн</u> салбар зөвлөл, Б.Болормаа, Б.Сансармаа.	Сургалтад хамрагдсан байна.	150 000 <u>төг</u>	<u>Жендэрийн</u> ажлын албатай хамтран ажиллах.
1.2	"Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн ёс зүйн хороодод зориулсан <u>жендэрийн</u> сургалт" хийх.	4 дүгээр улиралд	Яамны <u>жендэрийн</u> салбар зөвлөл, М.Мөнх-Эрдэнэ.	Сургалт зохион байгуулсан байна.	-	<u>Жендэрийн</u> ажлын албатай хамтран ажиллах.
1.3	Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн манлайлал сэдвээр сургалт зохион байгуулах.	3 дугаар улиралд	Яамны <u>жендэрийн</u> салбар зөвлөл, Г.Отгонбаяр.	Сургалт зохион байгуулсан байна.	300 000 <u>төг</u>	Яамны ёс зүйн хороотой хамтран ажиллах.
1.4	Албан хаагчдад мэдлэг олгоход чиглэсэн ярилцлага, сургалт зохион байгуулах /Сэдэв: <u>жендэр</u> , ба хүний эрх/.	3 дугаар улиралд	Яамны <u>жендэрийн</u> салбар зөвлөл, Г.Золбоо.	Сургалт зохион байгуулсан байна.	Төслийн зардлаар.	Канад Улсын Меррит /MERIT/ төсөлтэй хамтран ажиллах.
1.5	Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын тухай сургалт.	2 дугаар улиралд	Яамны <u>жендэрийн</u> салбар зөвлөл, Э.Номин-Эрдэнэ.	Сургалт зохион байгуулсан байна.	150 000 <u>төг</u>	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.
1.6	<u>Жендэрийн</u> эрх тэгш байдлыг хангах талаар яамнаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааг яамны цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах.	Жилдээ	Яамны <u>жендэрийн</u> салбар зөвлөл, Б.Ганзориг, Н.Хосбаяр.	Яамны цахим хуудас мэдээл байршуулсан байна.	-	Хэвлэл мэдээллийн <u>байгууллагуудтай</u> хамтрах.



Сангийн яамны Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэн Сангийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 39 тоот тушаалаар батлуулсан.


МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 17-нд Дугаар 39 Улаанбаатар хот

Салбар зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн яамны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар хийх ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэхийг салбар зөвлөлийн дарга (С.Наранцогт)-д үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн "Жендэрийн салбар зөвлөл шинэчлэн байгуулах тухай" 23 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

Хавсралт: ... хуудас.


Ч.ХҮРЭЛБААТАР

Сангийн сайдын 2020 оны
2 дугаар сарын 17-ны өдрийн
тушаалын нэгдүгээр хавсралт

**Сангийн яамны дэргэдэх
Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүн**

Зөвлөлийн дарга:	С.Наранцогт - Төрийн нарийн бичгийн дарга
Орлогч дарга:	Г.Золбоо - Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга
Гишүүд:	Э.Номин-Эрдэнэ - Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн; С.Сүхдэлгэр - Эдийн засгийн бодлогын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн; Б.Сансармаа - Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн; М.Мөнх-Эрдэнэ - Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн; Б.Ганзориг - Төсвийн хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн; Н.Саруул - Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн мэргэжилтэн; Ё.Отгонбаяр - Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн; Ц.Мөнхдэлгэр - Хөгжлийн санхүүжилтийн газрын Зээл, тусламжийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн; Д.Ганбаяр - Хууль, эрх зүйн газрын гэрээт ажилтан; Ц.Амгалан - Татварын ерөнхий газрын татварын улсын ахлах байцаагч; Х.Мөнхцэцэг - Гаалийн ерөнхий газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Гаалийн улсын байцаагч; Б.Болормаа - Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн.
Нарийн бичгийн дарга:	



Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж мэдээллийг яамны ажилтнуудад олгох, сургалт зохион байгуулах

- Сангийн яамны Жендэрийн салбар зөвлөлөөс 2019 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг гарган 2020 оны 1 дүгээр сард Жендэрийн ажлын албанд хүргүүлсэн.
- Сангийн яамны Жендэрийн салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг салбар зөвлөлийн гишүүдэд цахимаар хүргүүлэн санал авч батлуулсан.
- Монгол Улсад коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын халдвар илэрсэнтэй холбогдуулан “Халдварын болзошгүй эрсдэлээс сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А27 тоот тушаал батлуулсан. Тушаалаар амьсгалын замын цочмог халдвар, томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн **5 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асарсан эх, эцэг, асран хамгаалагчдад тав хүртэлх** хоногийн цалинтай чөлөөг холбогдох журмын дагуу олгох, бага насны буюу **0-12 насны хүүхэдтэй, гэрт нь асран халамжлах хүнгүй албан хаагчдын ажлын цагийг хорогдуулснаар тооцох, ажил үүргээ цахимаар** хийж гүйцэтгэх нөхцөл боломжоор хангаж ажиллахыг газрын дарга нарт үүрэг болгон хэрэгжилтийг хангаж ажилласан.



Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж мэдээллийг яамны ажилтнуудад олгох, сургалт зохион байгуулах

- Жендэрийн ажлын албанаас Жендэрийн үндэсний сургагч багшийг бэлтгэх стратеги болон ЖҮХ-ны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан **“Жендэрийн дунд шатны сургагч багш бэлтгэх”** цахим сургалтад 2020 оны 4 дүгээр сарын 10-11-ний өдрүүдэд хамрагдсан. Сургалтад Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын жендэр хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болормаа, жендэрийн салбар зөвлөлийн гишүүн, сургалт хариуцсан ажилтан Л.Сэлэнгэ нар ирц бүрэн оролцсон.





Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж мэдээллийг яамны ажилтнуудад олгох, сургалт зохион байгуулах

- Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн албан хаагчдыг чадавхжуулах ажлын хүрээнд Татварын ерөнхий газрын албан хаагчдад зориулан **“Жендэрийн үүрэг, жендэрийн харилцаа, жендэрийн хэвшмэл ойлголт”**-ын талаар үндсэн мэдлэг олгох сургалтыг 2020 оны 9 дүгээр сарын 04, 09 болон 10 дугаар сарын 08-ны өдөр тус тус зохион байгуулсан. Сургалтад Татварын ерөнхий газар болон нийслэл, дүүргийн Татварын хэлтсийн хүний нөөцийн /ёс зүйн хороо/ 30 албан хаагч, орон нутгийн Татварын хэлтсийн удирдах болон хуулийн зөвлөхүүд нийт 70 албан хаагчид хамрагдсан бөгөөд СЯ-ны ТЗУГ-ын жендэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Болормаа, сургалтын асуудал хариуцсан ажилтан Л.Сэлэнгэ нар удирдан явуулсан. Сургалт болсон тухай мэдээллийг яамны цахим хуудаст байршуулан олон нийтэд мэдээлсэн.



“ЖЕНДЭРИЙН ҮҮРЭГ, ХАРИЛЦАА ОЙЛГОЛТ”
СУРГАЛТАД ХАМРАГДАХ АЛБАН ХААГЧДЫН НЭВЭЛЭН ДЭВГЭЭН

2020.09.09

№	Өвөг нэр	Харилцаагчдын нэр, албан тушаал	Гарын үсэг
1	Э.Пүрэвсүрэн	ТЭГ-ын ТЗУГ-ын ТУС	
2	М.Эрэл	ТЭГ-ын ТЗУГ-ын Хувий нэм, сургалтын хэлтсийн ТУС	
3	М.Дамсараа	ТЭГ-ын ТЗУГ-ын Хувий нэм, сургалтын хэлтсийн ТУС	
4	М.Дамсараа	ТЭГ-ын ТЗУГ-ын Хувий нэм, сургалтын хэлтсийн ТУС	
5	М.Батбаяр	ТЭГ-ын ТЗУГ-ын Хувий нэм, сургалтын хэлтсийн ТУС	
6	М.Бат-Оюу	ТЭГ-ын ТЗУГ-ын Хувий нэм, сургалтын хэлтсийн ТУС	
7	Г.Дорж	ТЭГ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
8	Т.Орхон	ТЭГ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
9	М.Хувий	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
10	М.Хувий	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
11	Т.Орхон	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
12	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
13	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
14	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
15	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
16	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
17	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
18	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
19	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	
20	М.Батбаяр	СЭДТХ-ын Татварын хэлтсийн хувийн хэргийн хэлтсийн ТУС	

Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж мэдээллийг яамны ажилтнуудад олгох, сургалт зохион байгуулах

- Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Жендэрийн Үндэсний Хороо, Үндэсний Статистикийн Хороотой хамтран гаргасан **“Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлөх хүчин зүйлс”**-ийг тодруулах зорилгоор хийгдсэн томоохон хэмжээний суурь судалгаа түүний тайланг яамны нийт албан хаагчдад 2020.04.27-ны өдөр цахимаар хүргэж танилцуулсан.

Жендэрийн үндэсний хорооны ажлын албанаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор батлуулсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)”-г Татварын ерөнхий газарт 2020.08.27-ны өдөр албан тоотоор хүргүүлсэн. Төлөвлөгөөний 3.1 дэх хэсэгт **“НӨАТ-ын баримт бүртгүүлэх системийг ашиглаж эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэгт хамрагдах талаар болон эрүүл аж төрөх амьдралын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх мессеж, мэдээ түгээх”** гэж заасны дагуу ТЕГ-тай хамтран байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулж хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөж байна.



Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж мэдээллийг яамны ажилтнуудад олгох, сургалт зохион байгуулах

- Яамны нийт албан хаагчдад зориулан “**Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүй, хариуцлага**” сэдвээр Төрийн албаны зөвлөлийн Маргаан шалгах газрын ахлах шинжээч Г.Нансалмаа, Стратеги бодлого, төлөвлөлтийн газрын зөвлөх Ph.D. Д.Дэмчигсүрэн нар 2020 оны 10 дугаар сарын 02-ний өдөр сургалт явуулсан. Сургалтад яамны 85 албан хаагч хамрагдсан.





Зорилт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, тогтоомж мэдээллийг яамны ажилтнуудад олгох, сургалт зохион байгуулах



САНГИЙН ЯАМ




THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP

- Сангийн яам Дэлхийн банкны Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөлтэй хамтран “**Сангийн яамны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2019-2029/**”-ийг 2019 онд боловсруулж батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2020 онд Хүний нөөцийн хөгжлийн дэд хөтөлбөр буюу Нийгмийн баталгаа, Эрүүл мэнд, Карьер хөгжил, Сургалт хөгжил, гэсэн 4 дэд хөтөлбөрийг боловсруулахаар зөвлөх ажилтан сонгон шалгаруулж, ажлын төлөвлөгөө батлуулан ажиллаж байна.
- “**Нийгмийн баталгааг хангах**” болон “**Эрүүл мэнд**”-ийн дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд яамны нийт албан хаагчдаас судалгаа авах, ганцаарчилсан ярилцлага хийх, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг албан хаагчдын оролцоог ханган ажиллаж байна. Дэд хөтөлбөрийг боловсруулахдаа албан хаагчдын ажлын бүтээмжид эерэгээр нөлөөлөх, тогтвор суурьшилтай, сэтгэл хангалуун ажиллахад дэмжлэг үзүүлэх талаас хөтөлбөрийг анхаарч, жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг зөвлөх багтай хамтран тусган ажиллаж байна.



"НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ" дэд хөтөлбөр, "ЭРҮҮЛ МЭНД" дэд хөтөлбөр

Судалгаанд оролцсон



91 АЖИЛТАН


Судалгаанд Сангийн яамны 91 ажилтан буюу нийт ажилтнуудын 54.6% нь хамрагдсан.

Судалгаанд оролцогчдын дийлэнх олонх нь буюу 74% залуу ба дунд насныхан байсан.

- Дэд хөтөлбөрүүдийн гол зорилго нь Сангийн яамны ажилтан, албан хаагчид бүтээмжтэй, тогтвортой, сэтгэл ханамжтай ажиллах, тэдний эрүүл мэндийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж бие, сэтгэлзүйн хувьд эрүүл байж бүтээмжтэй, сэтгэл ханамжтай ажиллахад нь дэмжлэг үзүүлэхэд оршино.
- Дэд хөтөлбөрүүдийн үндсэн зарчимд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүний эрх, жендерийн тэгш байдал, адил тэгш боломжийг үргэлж харгалзах ба тэдгээрт харшлах аливаа үзлийг үл агуулна гэж заасан. Мөн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг албан хаагчдад болон тэдний гэр бүлд хүртээмжтэй байх талаас нь илүү анхаарч байна.

Зорилт 3. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийг жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин болгоно

- Жендэрийн мэдрэмжтэй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд яамны байрны талбайн ашиглалтыг нэмэгдүүлэх, агааржуулалт, салхивчийн системийг сайжруулах, давхар бүрд цайны өрөө гаргах, газар хэлтэс бүрийг хувцас солих өрөөтэй болгох зорилгоор 2019 оноос дамжин үе шаттай засварын ажлыг хийсэн. 2020 онд 2, 3, 7, 8 давхруудыг бүрэн засварлаж дуусгасан. Мөн 2 болон 5 дугаар давхруудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийг өрөөг шинээр байгуулсан.



1. Хувцас солих өрөө



2. Цайны өрөө



3. Уулзалтын өрөө



4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө



Зорилт 3. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийг жендэрийн мэдрэмжтэй ажлын орчин болгоно

Өмнө



Одоо





Зорилт 4. Сангийн сайдын болон зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үйл явцыг үе шаттайгаар жендэрийн мэдрэмжэй болгох

- Жендэрийн үндэсний хороо, Европын Холбооны санхүүжилтээр Дэлхийн банкны хэрэгжүүлж буй “Засаглалыг Бэхжүүлэх” төсөлтэй хамтран **“ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ”** төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Төслийг анхны танилцуулга семинарыг 2020.01.29-ний өдөр Сангийн яаманд зохион байгуулж, Монгол Улсад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн арга хандлагыг тодорхойлох, гаргасан саналыг тусгах, төслийн хүрээнд цаашид авч хэрэгжүүлэх алхмуудыг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан.
- Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-88 дугаар тушаалаар **“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал боловсруулж, холбогдох салбарын төсвийн төлөвлөлтөд туршин нэвтрүүлэх”** чиг үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг холбогдох талуудтай зөвшилцсөний үндсэн дээр байгуулсан.
- ЖМТ-ийн Ажлын хэсгийн анхдугаар уулзалтыг 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Сангийн яамны “Чагдаржав” танхимд зохион байгуулсан. Уулзалтаар Монгол Улсад ЖМТ-ийг хэрхэн нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явуулсан.





АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА